



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг
батлах тухай Г

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэхь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэхь заалт, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэхь заалт, 2016 оны 9 сарын 19-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь заалтыг “ТУЗ-ийн Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” хэмээн өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ХҮРЭЛБААТАР



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

Г

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, 77.4 дэхь заалтууд, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.23 дахь заалтууд, 2016 оны 9 сарын 19-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Мягмарын БАЯР

Дамбын ГЭРЭЛМАА

Такеша КАМБЭ

Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ

Түнрэвийн ОДМАА

Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ нарыг;


Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН

Дашдаваагийн ХУЛАН

Хидео САВАДА нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ХҮРЭЛБААТАР